

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ
БОДЛОГО, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”-Д ХИЙСЭН
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

АУДИТЫН КОД: /ДУА-2024/20-10-ШТА-ГА/

Дундговь дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудитор
Р.Мөнхтогтох Утас: 70592439

Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ
Утас: 70592225

Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Батсайхан

Аудитор Б.Гантуяа Утас: 7059-2208,

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим
хуудас: www.audit.mn

**“ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БОДЛОГО,
ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”-Д ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН
ХУРААНГУЙ ТАЙЛАН**

Огноо: 2024.11.25

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын
код:

ДУА-2024/20-
10-ШТА-ГА

Шалгагдсан
байгууллага,
нэгжийн нэр:

ХГБХХГ, аймгийн ЗДТГ-ын НБХ,
Хүүхдийн төлөө зөвлөл, Цагдаагийн
газар, ОБГ, ЭМГ, БШУГ

Аудитын нэр:

“ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БОДЛОГО,
ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”

Аудит хийсэн
бүтцийн нэгжийн
нэр:

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар

Аудит хийсэн баг,
албан тушаалтан:

Аудитын 3-р нэгж Ахлах
аудитор Т.Батсайхан,
аудитор Б.Гантуяа

Хоёр. Аудитын үр дүн:

2.1 Аудитын зорилго, хамрах хүрээ:

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт болон бий болсон үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдсэн.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ. Үүнд:

- Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, төлөвлөлтийн тогтолцоо оновчтой эсэх;
- Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөлт, төсөвлөлт үр өгөөжтэй, хүүхдэд ээлтэй байж чадсан эсэх;
- Хүүхэд хамгааллын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт үр дүнтэй эсэх.

Аудитад Хүүхэд хамгааллын тухай хуулийн хүрээнд хүүхэд хамгааллын чиглэлээр, үйл ажиллагаанд оролцдог Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл, Дундговь аймаг дахь Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Боловсрол шинжлэх ухааны газар, Хөгжлийн бэрхшээлтэй

хүний хөгжлийн төв, Сайнцагаан, Дэлгэрцогт, Дэрэн сумын Ерөнхий боловсролын сургуулиуд, Сайнцагаан сумын Цэцэрлэгүүд, дээрх сумдын Хамтарсан багууд зэрэг төрийн байгууллага, Ид шидийн орон Гэрэлтдэг ертөнц төрийн бус байгууллагуудын 2019-2023 оны баримт, мэдээллийг хамруулан аудитыг гүйцэтгэсэн. Аудитын явцад объект дээр ажиллаж, хүүхэд хамгааллын талаарх бодлогын баримт бичиг, төлөвлөлт, тайлагнал, хэрэгжилт, дотуур байрны орчин, үйлчилгээ, түр хамгаалах байрны стандарт, хамтарсан багийн үйл ажиллагааг шалгах хуудсаар газар дээр нь шалгасан.

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, судалгаа явуулах, ярилцлага хийх арга зүйг ашиглан аудитын хөтөлбөрт дурдсан хугацаанд нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан.

Аудитын дүн: БҮЛЭГ 1. Аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын нэгдсэн бодлого байхгүй, холбогдох байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүйгээс бодлого тогтолцоо алдагдсан байна.

Аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх орон нутгийн онцлогийг тусгасан хүүхэд хамгааллын бодлого байхгүй, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хүүхэд хамгааллын бодлого”-ыг, Ерөнхий боловсролын сургуулиуд БСШУС-ын 2018 оны “Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлого”-ыг баримтлан, гүйцэтгэлийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган ажилласан байна.

Харин цэцэрлэгүүд БСШУС-ын 2020 оны “Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлого”-ыг өөрсдийн онцлогт тохируулан боловсруулж мөрдөж ажиллажээ.

Аймгийн Засаг даргын 2022 онд хүүхдийн төлөө зөвлөлийг шинэчлэн 19 хүний бүрэлдэхүүнтэй, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог 15 хүний бүрэлдэхүүнтэй тус тус байгуулжээ.

Хүүхдийн төлөө зөвлөлийн 2019-2022 онуудад хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилт, хурлын тэмдэглэл бусад холбогдох баримт материалыг аудитын явцад ирүүлээгүй.

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны 2021-2023 онуудын гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт, хурлын тэмдэглэл зэрэг бусад холбогдох баримт материалыг аудитад ирүүлээгүй, байхгүй гэсэн тайлбар өглөө.

Иймд Хүүхэд хамгаалах зөвлөлийг шинэчлэн байгуулах, зөвлөлүүдийн үйл ажиллагааг тогтмолжуулж, ажлын хариуцлагыг сайжруулах, хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Аймгийн хэмжээнд хүүхэд гэр бүл хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагууд хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнээс гадна дараах байгууллагууд хүүхэд хамгааллын бодлогыг дэмжин ажиллаж байгаа нь төрийн байгууллагуудын хүүхдийн хөгжил хамгааллын талаар чиг үүргээ хэрэгжүүлэхэд ихээхэн дэмжлэг болж байна.

Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театр нь 2009 оноос үйл ажиллагаагаа явуулж уртын дуу, үндэсний хөгжим, язгуур урлаг, драм, бүжиг, уран зураг зэрэг 6 дугуйланд 20 гаруй төрлөөр хичээллэж, жилдээ 200 гаруй хүүхдийг урлагийн боловсрол олгох сургалтад хамруулсан байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд олон нийтийн хандиваар 2022 онд “Ид шидийн орон” хүүхэд хөгжлийн төв байгуулагдан 2023 онд 17 төрлийн сургалтад 1,680 хүүхдийг хамруулж, тэгш хүртээмжтэй хөгжих боломжийг үнэ төлбөргүй олгож байна.

Сумдын хүүхдийн элч нар 13 сумын 14 хүүхдийн элч сонгогдсоноос идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 9 сумын 10 элч байна.

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд 2023 оноос Дундговь аймагт “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв”-ийг байгуулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон насанд хүрэгчдэд амьдралынх нь эрт үед хөгжлийн дэмжлэг үзүүлэх, хувь хүний онцлог, амьдралын хэв маягт тохирсон туслах бүтээгдэхүүнээр хангах, бие даан амьдрах чадварт сургах, гэр бүлд нь дэмжлэг үзүүлэх, эрүүл мэндийн болон нийгмийн сэргээн засах тусламж үйлчилгээгээр дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгэмд бусдын адил идэвхтэй оролцох, хөдөлмөр эрхлэн ажил орлоготой амьдрахад нь дэмжлэг үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын талаарх нэгдсэн мэдээлэл байхгүй, харин үйл ажиллагааны мэдээлэл дараах чиглэлээр тус тусдаа нэгтгэгдэж байна. Үүнд:

1. Аймгийн ЗДТГ-ын нийгмийн бодлогын хэлтэс нь Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан “Хүүхэд хамгааллын талаарх үйл ажиллагаа”-ны хэрэгжилтийг;

2. ХГБХХГ-ын цогц систем **Able программд** уралдаанч хүүхдийн дэлгэрэнгүй мэдээлэл, уяач нар, зохион байгуулагдаж байгаа морины уралдаан, эрсдэлт хүүхдийн талаар, хүүхдийн зуслангийн мэдээлэл, зусланд амарсан хүүхэд бүрийн мэдээлэл;

3. Аймгийн Цагдаагийн газарт насанд хүрээгүй хүнээс үйлдэгдсэн гэмт хэрэг болон насанд хүрээгүй хүний эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн мэдээллийг;

4. ХГБХХГ дахь хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлагын тоон мэдээлэл.

5. **Статистик мэдээ.** Хүүхэд хөгжил хамгааллын үйлчилгээ, ирсэн өргөдөл гомдол, зөрчил шалган шийдвэрлэлт, хараа хяналтгүй болон уралдаанч хүүхдийн талаар, сургалт нөлөөллийн арга хэмжээ зэрэг мэдээллийн статистик мэдээг улирал бүр гараар боловсруулан ХГБХХГ-т хүргүүлдэг байна.

Иймд анхан шатны байгууллагуудаас тайлан мэдээллийг авч нэгтгэн дүн шинжилгээ хийж, мэдээллийн санг бүрдүүлэн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж, боловсруулах шаардлагатай байна.

Хүүхэд хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэгч төрийн байгууллагуудын хүний нөөцийн байдлыг аудитын хамрах хугацаагаар судалж үзэхэд:

1. Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн боловсрол, хүүхэд гэр бүлийн бодлого хариуцсан мэргэжилтэн 3 удаа солигдсон, одоогийн байдлаар соёл урлаг, биеийн тамир спортын хариуцсан мэргэжилтнийг хавсран гүйцэтгэж байна.

2. Цагдаагийн байгууллагын бүтэц орон тооны жишиг нормативт 8.0 мянган хүүхэд тутамд 1 хүүхдийн байцаагч байхаар заасан байна. 2023 оны байдлаар аймгийн хэмжээнд 0-18 хүртэлх насны 16,872 хүүхэдтэй байхад Цагдаагийн газар 2019-2023 онуудад хүүхдийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтний орон тоог 1-ээр баталсан нь ажлын ачаалал их байгааг харуулж байна.

3. ХГБХХГ-т боловсон хүчний судалгаагаар хүүхдийн эрхийн улсын байцаагч 1, хүүхдийн хөгжил хамгаалал хариуцсан мэргэжилтэн 3, хүүхдийн хөгжил оролцоо хариуцсан мэргэжилтэн 6 удаа өөрчлөгдсөн, 4-9 сарын хугацаанд орон тоо сул байсан. 2024 оны 10 дугаар сарын байдлаар хүүхдийн асуудал хариуцсан 4 мэргэжилтнээс хүүхдийн эрх хамгаалал хариуцсан мэргэжилтэн, хүүхдийн хөгжил оролцоо хариуцсан мэргэжилтэн байхгүй, хавсран гүйцэтгэж байна. Мөн мэргэжлийн сэтгэл зүйч байхгүй.

4. Ерөнхий боловсролын 19 сургууль, 22 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаагаас Сайнцагаан сумын Эрдмийн далай цогцолбор, Мандал сургуулиудад сэтгэл зүйч ажиллаж байна. Боловсролын салбарт ажиллаж байгаа сэтгэл зүйчийн албан тушаалын тодорхойлолт, ёс зүйн дүрэм батлагдаж ирээгүй байна.

5. Дундговь аймагт 2024 оны 10 сарын байдлаар Сайнцагаан сумын ЗДТГ-т 2, бусад сумдад 1, нийт 16 нийгмийн бодлогын мэргэжилтэн байгаагаас 10 нь үндсэн орон тоо, 6 нь хавсран ажиллаж байна. Сумдын нийгмийн бодлогын мэргэжилтнийг мэргэжлээр нь авч үзвэл нийгмийн ажилтан 1, бусад

нь эрх зүйч, боловсрол судлаач, багш, төрийн захиргааны менежмент, тусгай хэрэгцээт боловсрол зэрэг мэргэжилтэй байна.

Иймд дутагдалтай байгаа ажилтны орон тоог яаралтай бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөл боломжийг судалж шийдвэрлэх, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч зэрэг шаардлагатай мэргэжилтнийг бэлдэх хүний нөөцийн бодлого боловсруулж ажиллах шаардлагатай болсон байна.

БҮЛЭГ 2. Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг судалгаанд үндэслэн тооцож төлөвлөөгүй ч батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, ил тод тайлагнасан байна.

Аймгийн ХГБХХГ-ын төсвийг сүүлийн 5 жилээр харьцуулж үзэхэд батлагдсан төсөв 2022 онд буурч, бусад жилд өмнөх оноос 4.5-51.6 хувийн өсөлттэй байна.

Үүнээс хүүхэд хамгааллын үйлчилгээний зардал 5.0-82.9 хувиар өссөн, зардлын ихэнх хэсгийг урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажил зохион байгуулах, боловсон хүчнийг чадавхжуулах чиглэлд зарцуулсан байхад насанд хүрээгүй хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэрэг жил бүр өссөн байна.

Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардал ХГБХХГ-ын нийт төсвийн 11.5-20.1 хувийг эзэлж байна.

Хүүхдийн тусламж 108 дуудлага болон бусад мэдээллээр хүүхдийн эрх зөрчигдсөн тухай мэдээллийг хамтарсан багт тэмдэглэлээр хүргүүлдэг байна. Тухайн мэдээллийг хамтарсан баг хүлээн авч шалган зөрчил биш гэж үзвэл илтгэх хуудас бичин хааж, зөрчил гэж үзсэн тохиолдолд дараагийн шатны арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Зөрчлийн болон гэмт хэргийн шинжтэй мэдээллийг ХНХС, ХЗДХС-ын 2017 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн А/120, А/178 тоот хамтарсан тушаалаар баталсан маягтын дагуу баримтжуулсан байна.

Аудитын явцад кейсийн баримт материал бүрдүүлэлтийг түүвэрлэн үзэхэд бүрдүүлэлт харилцан адилгүй, зарим кейсийн хамтарсан багт мэдээлэл хүргүүлсэн маягт, ярилцлагын тэмдэглэл, аюул, илтгэх хуудсыг гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.

Хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн кейсийн баримт нь архивд нууцын зэрэглэлгүй хадгалагдаж байна.

Иймд нууц хадгалах гэрээний үүргийн биелэлтийг тооцож, баримтжуулж хэвших, баримт материалын нууцын түвшнийг тогтоож, кейсийн баримтуудыг нууцын зэргээр ялгаж архивлах, нууц хадгалах, хамгаалах тухай хууль тогтоомж, журмыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

БҮЛЭГ 3. Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт хангалтгүй, үйл ажиллагааг үнэлж дүгнэх нарийвчилсан шалгуур үзүүлэлтгүй, Олон улсын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Дундговь аймгийн хэмжээнд Хүүхэд хамгааллын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх заалтын дагуу оролцогч талуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх шалгуур үзүүлэлт, нарийвчилсан аргачлалыг салбарын онцлогт нийцүүлж батлаагүй байна.

ХГБХХГ Хүүхэд хамгааллын тухай хуулийн заасны дагуу хяналт, шинжилгээ үнэлгээ хийгээгүй, Хүүхдийн төлөө зөвлөл хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна. ХГБХХГ-т 2019-2023 оны хооронд нэгтгэгдсэн судалгаа шинжилгээ, хяналт үнэлгээ хийсэн мэдээлэл байхгүй байна.

Олон улсын байгууллагаас хүүхэд хамгааллын чиглэлээр Засгийн газарт өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

2016-2019 оны төлөвлөгөөг Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоолоор 18 арга хэмжээ, 2023-2025 оны төлөвлөгөөг 2023 оны 357 дугаар тогтоолоор 24 арга хэмжээг тус тус баталсан байна. Дээрх төлөвлөгөөний дагуу ХГБХХГ, аймгийн хүүхдийн төлөө зөвлөлөөс өөрт хамааралтай заалтын дагуу хэрэгжүүлж ажилласан тайлан байхгүй байна.

Боловсролын салбарын үйл ажиллагааны хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг аудитын явцад ЕБС, СӨБ-оор нэгтгэж гаргалаа.

ЕБС-ын 2019-2023 оны хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт 70-100 хувь, дунджаар 88.3 хувьтай байна. СӨБ-ийн бодлогын баримт бичигт дунджаар 11 арга хэмжээ төлөвлөж, түүний хэрэгжилт дээрх онуудад 80-100 хувь, дунджаар 88.8 хувийн хэрэгжилттэй байна. Дотуур байрны орчин, үйлчилгээний стандарт MNS 6781:2019-т нийцсэн эсэхийг шалгалаа. Энэ хүрээнд Сайнцагаан сумын Эрдмийн далай сургуулийн стандартаар байрын багш 4, жижүүр 8 байхаар заасан байна. Гэтэл байр тус бүр 1 багш, 2 жижүүр ажиллаж байгаа нь стандарт хангагдахгүй байгааг харуулж байна.

Дундговь аймгийн Эрүүл мэндийн газраас хүүхэд хамгааллын талаарх баримталж буй бодлогын баримт бичиг, төлөвлөлт, хэрэгжилтийн тайлан холбогдох баримт материал байхгүй учир эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгаалал хэрхэн хангагдаж байгаа талаар дүгнэлт өгөх боломжгүй байна.

2019-2023 онд албан ёсны зөвшөөрөлтэй хурдан морины уралдаан 106 удаа зохион байгуулагдаж, 1239 унаач хүүхдийг даатгалд бүрэн хамруулсан байна. Энэ хугацаанд 35 унаач хүүхэд мориноос унаж хөнгөн, 1 унаач хүүхэд хүнд гэмтсэн байна.

Хүүхэд хамгааллын хангах зорилгоор Онцгой байдлын газартай хамтран гамшгийн үед аюул ослоос хэрхэн сэргийлэх сургалтууд зохион байгуулсан байна. Онцгой байдлын газраас гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үеийн төлөвлөгөө түүний хэрэгжилт, хяналт үнэлгээний талаарх материал, судалгаа, тоон мэдээллийг аймгийн гамшгийн төлөвлөгөөнд тусгагдсан, тухайн үед үүссэн нөхцөл байдалд тохируулан төлөвлөгөөг боловсруулж ажилладаг гэсэн шалтгаанаар аудитын хугацаанд ирүүлээгүй. Энэ нь гамшгийн үеийн онцгой нөхцөлд хүүхдийг хэрхэн хамгаалж буй мэдээлэлтэй танилцах боломжгүй болгож, аудитын гүйцэтгэлийн үе шатанд хүндрэлтэй нөхцөл байдлыг бий болгож байна.

Хүүхдийн эрхийн тухай конвенц нь НҮБ-аас баталсан хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын гэрээ юм. Монгол Улс нь Хүүхдийн эрхийн тухай конвенцыг 1989 онд баталж, 1990 оны 9 дүгээр сарын 02-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцын 5 дугаар тайланд өгсөн дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийн явцыг шалгахад аймгийн ХГБХХГ-аас төлөвлөсөн арга хэмжээ түүний хэрэгжилтийг тооцож гаргасан баримт материал олдоогүй болно.

ХГБХХГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд конвенцын үүргийг тусгагдаагүйгээс орон нутгийн хэмжээнд конвенцын нэгдсэн үүрэг, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байх үр дагавартай байна. Иймд орон нутгийн байгууллагаас хэрхэн, ямар чиг үүргийн оролцоотой байхыг тодорхой болгох зорилгоор “конвенцын үүргийг хэрэгжүүлэн ажиллах” гэх арга хэмжээг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд, бодлогын асуудлыг Хүүхдийн төлөө зөвлөл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгаж, тодорхой давтамжтайгаар хэрэгжилтийг хянах зэргээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай.

ДҮГНЭЛТ

Хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа байгууллагууд чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, үйл ажиллагаа уялдаа холбоо хангалтгүй, хүүхдийн хэрэгцээ шаардлага, тулгамдсан асуудлыг нэгтгэн дүгнэж судалгаа хийдэггүйгээс хүүхэд хамгаалах бодлого тогтолцоо алдагдсан, хамгааллын арга хэмжээг оновчтой төлөвлөж чадаагүйгээс хүүхдийн эрх зөрчигдөх, хохирох үзүүлэлт буурахгүй байна.

- ✓ *Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ нь хууль тогтоомж, урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэхээр баталсан бодлогын баримт бичигтэй нийцсэн, хөтөлбөрийн хүрээнд нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан ч үр дүнг тооцож ажиллаагүй.*

- ✓ ХГБХХГ болон Хүүхдийн төлөө зөвлөл, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нь хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлдэггүйгээс анхан шатны байгууллагуудын хүүхэд хамгааллын бодлогын тогтолцоо алдагдсан байна.
- ✓ ХГБХХГ нь чиг үүрэг бүхий байгууллагуудын тайлан мэдээг нэгтгэн дүгнэж, судалгаа шинжилгээ хийдэггүй, мэдээллийн санг бий болгоогүйгээс ажлын уялдаа холбоо хангалтгүй байна.
- ✓ Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулахад шаардлагатай мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байна.
- ✓ Хүүхэд хамгааллын чиглэлээр зарцуулсан төсөв хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан, үйл ажиллагаа явуулахад шаардлагатай зардлыг хуваарилж, ил тод тайлагнасан байна.
- ✓ Түр хамгаалах байрны үйл ажиллагааны санхүүжилтийг шийдвэрлүүлээгүйгээс хүүхэд хамгааллын цогц үйлчилгээ үзүүлэхэд хүндрэлтэй байна.
- ✓ Хүүхэд хамгааллын үйлчилгээнд нууц хадгалах гэрээ хийсэн ч гэрээний үүргийн биелэлтийг тооцдоггүй, нууц хадгалах, хамгаалах тухай хууль тогтоомж, журмыг огт хэрэгжүүлээгүйгээс хувь хүний мэдээллийн нууц алдагдах, хүүхдийн эрх ноцтой зөрчигдөх эрсдэлтэй нөхцөл үүссэн байна.
- ✓ Оролцогч талуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх шалгуур үзүүлэлт, нарийвчилсан аргачлалыг салбарын онцлогт нийцүүлж батлаагүй байна.
- ✓ Олон улсын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхээр Засгийн газрын баталсан төлөвлөгөөний дагуу ХГБХХГ, аймгийн хүүхдийн төлөө зөвлөлөөс өөрт хамааралтай заалтын дагуу хэрэгжүүлж ажилласан тайлан байхгүй байна.
- ✓ Олон улсын байгууллага болон төрийн бус байгууллагаас зохион байгуулсан үйл ажиллагаа, хөтөлбөрийн үр дүнг тооцож, нэгтгэн дүгнээгүй байна.
- ✓ Бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ үнэлгээг бодитой хийж үнэн зөв тайлагнаж байна.
- ✓ Хүүхэд хамгааллын бодлогын төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг үнэлэхдээ нийгэмд гарч буй эерэг нөлөөг үнэлэхгүй байна.
- ✓ Эрсдэлд бүхий гэр бүлийн хэмжээнд зан үйлийг өөрчлөхөд хугацаа их шаарддаг учир эерэг үр дүнд нөлөөлж байна.

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

ҮАГ-аар дамжуулан ХГБХХГ-т:

- ✓ Мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдүүлэх, мэдээ мэдээллийг боловсруулах, нэгтгэх, ашиглах үйл явцыг боловсронгуй болгох, ажлын ачааллыг бууруулах

Аймгийн Засаг даргад:

- ✓ Хүүхдийн хэрэгцээ шаардлага, тулгамдсан асуудлын талаар судалгаа хийж, нэгтгэн дүгнэж орон нутгийн онцлогт тохирсон хүүхэд хамгаалах бодлогыг оновчтой төлөвлөж хэрэгжүүлж ажиллах;
- ✓ Хүүхдийн төлөө зөвлөлийг шинэчлэн байгуулах, зөвлөлийн хуулиар хүлээсэн чиг үүргийн бүрэн хэрэгжүүлж, үйл ажиллагааг тогтмолжуулж, оролцогч талуудыг арга зүйгээр хангаж, үр дүнг үнэлэх;
- ✓ Түр хамгаалах байрны санхүүжилтийг хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэж, хэвийн ажиллах нөхцөлийг хангах;
- ✓ ХГБХХГ, оролцогч талууд, төрийн бус байгууллагууд болон ажлын хэсгүүдийн үйл ажиллагааг уялдуулж, хүүхэд хамгааллын үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ авч ажиллах;

Аймгийн ХГБХХГ-т:

- ✓ Дутагдалтай байгаа ажилтны орон тоог яаралтай бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөл боломжийг судалж шийдвэрлэх, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч зэрэг шаардлагатай мэргэжилтнийг бэлдэх хүний нөөцийн бодлого боловсруулж ажиллах;
- ✓ Оролцогч талуудаас тайлан мэдээллийг авч, нэгтгэн, дүн шинжилгээ хийж, мэдээллийн санг бүрдүүлэн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж, үр дүнг тооцон ажиллах;
- ✓ Хүүхдийн эрхийн зөрчлийн шалтгаан нөхцөлийг судалж урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээнд зарцуулагдаж байгаа төсөв хөрөнгийг хүүхдийн эрхийн зөрчлийг бууруулахад оновчтой төлөвлөж ажиллах;
- ✓ Нууц хадгалах гэрээний үүргийн биелэлтийг тооцож баримтжуулж хэвишх, баримт материалын нууцын түвшнийг тогтоож, кейсийн баримтуудыг нууцын зэргээр ялгаж архивлах, нууц хадгалах, хамгаалах тухай хууль тогтоомж, журмыг хэрэгжүүлж ажиллах;
- ✓ Олон улсын байгууллагаас Засгийн газарт хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж, үр дүнг тооцож ажиллах;
- ✓ Кейсийн хамгаалах үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө, хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг бий болгох.

Монгол Улс, Дундговь аймаг 48090, Сайнцагаан сум, Нарлаг
баг, Нутгийн удирдлагын ордон Утас/Факс: 70-59-24-39
E-mail: dundgovi@audit.gov.mn 